

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 01 дүгээр
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Д.Ганбат**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2014 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал дүгнэлтийг гаргалаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, С.Одонтуяа нар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар дараах агуулга бүхий зарчмын зөрүүтэй саналууд гаргасныг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ. Үүнд:

1. Төслийн холбогдох заалтыг “Монголбанк, түүнээс эрх авсан банкинд алтаяа худалдвал нөөц ашигласны төлбөр 2.5, нэмэлт төлбөр нь 0 хувьтай тэнцүү” гэж өөрчлөн найруулах, “энэ заалтыг батлагдсан өдрөөс нь эхлэн 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө” гэсэн шинэ зүйл төсөлд нэмэх, төслийн 2 дугаар зүйлийг “Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2 дахь заалтын “47.3.1-д зааснаас бусад” гэснийг 47.3.1, 47.3.3-т заасан Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтнаас бусад” гэж өөрчлөн найруулах саналууд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг авлаа.

2. Төслийн зарим зүйл, заалтууд зөрчилдсөн мөн холбогдох бусад хуулиар зохицуулсан харилцаа давхардсан тул төслийн 1 дүгээр зүйлийн 3, 4, 5, 8 дахь заалт болон 3, 4 дүгээр зүйлийг тус тус хасах саналууд дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг “энэ хуулийн 46.1-д заасан сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь алтны сорьцыг тогтоох лабораторийг орон нутагт байгуулан ажиллуулж болно” гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Ц.Нямдорж нарын “Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд энэ хуулийн 47.3.2-т заасан нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү” гэсэн саналуудыг дэмжээгүй болно.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжсэн, дэмжээгүйгээр нь бүлэглэн Табухэнд тараасан болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ГАРАМГАЙБААТАР



Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг. Байнгын хорооны дэмжсэн санал:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дахь заалт буюу 35.6 дахь хэсгийн “тухайн жилдээ багтааж бүрэн тушаана.” гэснийг “тухайн санхүүгийн жилдээ багтааж тушаана.” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: УИХ-ын гишүүн Д.Ганбат, Б.Гарамгайбаатар,
Д.Зоригт, С.Одонтуяа,**

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг 3 дахь заалт болгон доор дурдсан байдлаар өөрчлөн найруулах:

“3/47 дугаар зүйлийн 47.3.3 дахь заалт:

47.3.3. Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд энэ хуулийн 47.3.2-т заасан нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2,5 хувь, энэ хуулийн 47.5-т заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.”

**Санал гаргасан: УИХ-ын гишүүн Д.Ганбат, Б.Гарамгайбаатар,
Д.Зоригт, С.Одонтуяа,**

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 3, 4, 5, 8 дахь заалтыг тус тус хасах.

**Санал гаргасан: УИХ-ын гишүүн Д.Ганбат, Б.Гарамгайбаатар,
Д.Зоригт, С.Одонтуяа,**

4. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсан байдлаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“**2 дугаар зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2 дахь заалтын “47.3.1-д зааснаас бусад” гэснийг 47.3.1, 47.3.3-т заасан Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтнаас бусад” гэж өөрчилсүгэй.”

**Санал гаргасан: УИХ-ын гишүүн Д.Ганбат, Б.Гарамгайбаатар,
Д.Зоригт, С.Одонтуяа,**

5. Төслийн 3 дугаар зүйлийг хасах.

**Санал гаргасан: УИХ-ын гишүүн Д.Ганбат, Б.Гарамгайбаатар,
Д.Зоригт, С.Одонтуяа,**

6. Төслийн 4 дүгээр зүйлийг хасах.

**Санал гаргасан: УИХ-ын гишүүн Д.Ганбат, Б.Гарамгайбаатар,
Д.Зоригт, С.Одонтуяа,**

7. Төсөлд “Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд нөөц ашигласны төлбөр 2.5 хувь, нэмэлт төлбөр 0 хувьтай тэнцүү гэсэн Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.3 дахь заалтыг батлагдсан өдрөөс нь эхлэн 2019 оны 01 дүгээр

сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.” гэсэн агуулга бүхий шинэ зүйл нэмэх.

**Санал гаргасан: УИХ-ын гишүүн Д.Ганбат, Б.Гарамгайбаатар,
Д.Зоригт, С.Одонтуяа,**

Хоёр. Байнгын хорооны дэмжээгүй санал:

**1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг доор дурдсан байдлаар өөрчлөн
найруулах:**

“46.6.Энэ хуулийн 46.1-д заасан сорьцын асуудал эрхэлсэн төрийн
захиргааны байгууллага нь алтны сорьцыг тогтоох лабораторийг орон нутагт байгуулан
ажиллуулж болно.”

**Санал гаргасан: УИХ-ын гишүүн Д.Ганбат, Б.Гарамгайбаатар,
Д.Зоригт, С.Одонтуяа,**

**2.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг “47.3.3.Монголбанк, түүнээс эрх
олгосон банкинд худалдсан алтанд энэ хуулийн 47.3.2-т заасан нөөц ашигласны
төлбөрийн хэмжээ 5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0
хувтай тэнцүү” гэж өөрчлөх.**

**Санал гаргасан: УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ,
С.Бямбацогт, Ц.Нямдорж**

---ooOoo---